Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР, СТРАТЕГИ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ С.ЖАРГАЛСАЙХАНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин: Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрэх түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Эмнэлгийн анхан болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний чиглэлээр хөгжлийн бодлогын хувилбар боловсруулах, нэгдсэн зохицуулалт хийх зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. 67 | Арга хэмжээ 1.1. *ЗГҮАХ-2.1.7.3* Урт хугацааны тусламж үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв (ЭМДС)-аас санхүүжүүлнэ. | Урт хугацааны тусламж, үйлчилгээний загварын төслийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах, гүйцэтгэлийн хувь | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар турших төлөвлөгөө батлах тухай” А/127, А/333 тушаалын хүрээнд | 100% | Урт хугацааны тусламж үйлчилгээний загвар боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг боловсруулан олон улсын загвар, туршлагаас, тухайлбал Япон, Тайланд, Вьетнам улсуудын загварыг харьцуулан судалсан. Урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг боловсруулахад хууль эрх зүйн орчныг сайжруулах нь тулгамдсан асуудал байсан. Иймд Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн | 2024.01 2024.06 | 80% |
| 2. | Дэд арга хэмжээ 1.1.1 Урт хугацааны тусламж үйлчилгээний загвар боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг гаргах, олон улсын загвар, туршлагыг судална. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | | 30% | | 2024.03 2024.06 | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3 байршилд туршилтын төсөл хэрэгжүүлж байна. | | төсөлд ахмадын цогц тусламж үйлчилгээ, урт хугацааны тусламж, үйлчилгээний нэр төрөл, тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагатай холбоотой 3 заалт, дагалдаж гарах Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгч, УИХ-ын НББХ-ны дэд ажлын хэсэгт ажилласан. | | |
| 3. | Дэд арга хэмжээ 1.1.2 Урт хугацааны тусламж үйлчилгээний загварын төсөл боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, саналыг тусган боловсруулах | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | | 50% | 2024 онд ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний шинэ загварыг үргэлжлүүлэн туршилтаар хэрэгжүүлж байгаа Дархан-Уул аймгийн АХТ, Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдсэн эмнэлэг, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Ачлалт хүүхдүүд” ТББ-ын ажиллагсад, тухайн орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулсан сургалт, хэлэлцүүлэг 2 удаа зохион байгуулсан. | 2024.04<br>2024.06 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төслийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийгдэж байна.<br>ХНХЯ-тай хамтран хэрэгжүүлж буй төлөвлөгөөний дагуу “Кейс менежмент”-ийн заавар боловсруулж туршилтын төсөл хэрэгжүүлэгч 3 газрын төр, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулсан сургалт, хэлэлцүүлэгт 24 хүнийг хамруулсан. | | |
| 4. | Дэд арга хэмжээ 1.1.3 Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар батлуулах | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 0 | 20% | Засаг захиргааны 3 өөр түвшинд загвар байдлаар хэрэгжүүлж байгаа урт хугацааны тусламж үйлчилгээний төслийн хэрэгжилтэд үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд 2025 оны 2 сард тайлан гарна. Үнэлгээнд үндэслэн Монгол улсад тохирох урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг сонгох юм. | 2024.09<br>2024.12 | 0% |
| **Зорилт 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж байгаа хууль, эрхзүйн орчинг боловсронгуй болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл боловсруулах зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь заалтын хүрээнд | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн өөрчлөлт УИХ-ын чуулганы нэгдсэн | Журам Засгийн газрын тогтоолоор | “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам”-ын төсөлд яамдаас | 2024.01.12<br>2024.04.12 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам” боловсруулах | | хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан. | батлагдсан байна. | 2024.01.09-ний өдрийн 1а/90 албан бичгээр санал авч нэгтгэн боловсруулж 2024.02.15-ны өдрийн 1а/639 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2024.02.28-ны өдрийн хуралдаанаар журмын төслийг хэлэлцүүлсэн нь ЗГ-ын 78 дугаар тогтоолоор эцэслэн батлагдсан. | | |
| 2. | Арга хэмжээ 2.2. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд чиг үүргийн дагуу санал тусгах | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдсэн. | Хуулийн төсөлд санал өгөх | Хуулийн ажлын хэсэгт “Урт хугацааны тусламж үйлчилгээ”-ний тодорхойлолтын талаар үндэслэл, тайлбар бичиж санал өгсөн. | 2024.02 | 70% |
| 3. | Арга хэмжээ 2.3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд эрүүл мэндийн салбарын бүсчлэлийн бодлогын хувилбарт тусгах эмнэлгийн тусламжийн чиглэлээр санал боловсруулах | Бодлогын хувилбарт тусгах санал | - | Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийсэн байна. | Эрүүл мэндийн бүсчлэлд эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж бүсийн хүн амын өвчлөл, нас баралтын статистик тоон мэдээллийг газарзүйн зураглалаар гаргасан. ЭЗХЯ-аас 2024.02.22-нд зохион байгуулсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг | 2024.02.01 2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хуралд эрүүл мэндийн салбарын бүсчлэлийн саналыг танилцуулж хэлэлцүүлсэн.<br>БХҮБ-д Салбарын бүсчлэлийн талаар туссан асуудлаар 2024.06.03-ны өдрийн удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулга хийсэн. | | |
| **Зорилт 3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр салбар хоорондын төрийн бус иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, олон улсын төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. Салбарын холбогдох хууль тогтоомжийн шинэчлэл, түүнийг хэрэгжүүлэх талаар салбар хоорондын төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангах арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, тайлан | - | | Нийт ажил 4. Үүнд:<br>- ӨЭМТ-ийн удирдах ажилтны зөвлөгөөний салбар хэлэлцүүлэгт анхан шатны тусламж үйлчилгээний бодлого, хэрэгжилтийн асуудлаар илтгэл хэлэлцүүлсэн.<br>- “Сувилагч танаараа бахархъя” арга хэмжээний “Сувилахуйн хүний нөөцийн хөгжил” салбар хуралдаанд сувилахуйн хүний нөөц, нийгмийн баталгааны асуудлаар илтгэл | 2024.02<br>2024.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцүүлж панелистаар оролцсон.<br>- АХБ, ХНХЯ, ЭМЯ-ны хамтарсан Бүсийн техникийн туслалцааны TA9928 төслийн хүрээнд 2024.05.28-30-нд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Мандал сумд ажиллан төслийн удирдах хорооны уулзалтыг зохион байгуулж холбогдох байгууллага, хамтрагч талуудыг оролцуулсан.<br>- Монголын Эмч нарын VII их хурал, Багийн эмч нарын зөвлөгөөний үндсэн илтгэлүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлого, эрхзүйн шинэчлэлийг тусган удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хүргэсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.<br>93 | Арга хэмжээ 3.2. *МУХТЖҮЧ 9.1.2 ЗГҮАХ-2.1.13.1* Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлнэ. | Үнэлгээний тайлан | Нийслэлийн Чингэлтэй, Хан-Уул дүүргийн түвшинд 2023.10.01-ээс эхлэн туршилтын төсөл хэрэгжүүлж эхэлсэн. | 50% | Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор анхан болон лавлагаа шатлал хооронд интеграцчлалын эмнэлзүйн, үйл ажиллагааны, үйлчилгээний хувилбаруудыг нийслэлийн Чингэлтэй, Хан-уул дүүрэгт 2023 оны 10 сарын 1-ээс эхлэн туршин хэрэгжүүлж явцын хяналт, үр дүнгийн талаар төслийн багтай хамтран ажиллаж байна. | 2024.01<br>2024.06 | 80%<br>70% |
| 3 | Дэд арга хэмжээ 3.2.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн туршилтын төсөлд үнэлгээ хийх асуумж боловсруулах | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 0 | 50% | Хоёр дүүргийн туршилтын төслийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх асуумжийг эмнэлзүйн болон үйлчилгээний интеграци, бусад нэмэлт асуудлуудыг тусган 4 чиглэлээр боловсруулж явцын үнэлгээ хийгдсэн. Үйл ажиллагааг үнэлэх асуумж 3 бүлэг 23 асуумжтай, үр дүнг 4 өвчний үзүүлэлтээр тооцсон. | 2024.03<br>2024.04 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Дэд арга хэмжээ 3.2.2 Өрхийн эрүүл мэндийн төвийн туршилтын хувилбарт үнэлгээ хийх | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 0 | 50% | Өрхийн эрүүл мэндийн төвийн туршилтын хувилбарт явцын үнэлгээ хийгдэн тайлан гарсан. | 2024.05 2024.06 | 30% |
| **Зорилт 4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлт, хөгжлийн бодлогын уялдаа холбооны талаар засгийн газар, бусад яамдыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох судалгаа хийх | Судалгааны тайлан | - | 100% | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох судалгааг 2020-2024 оныг хамруулах хийхээр ЭМХТ-ийн бодлогын судалгааны албантай хамтран ажиллаж аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас холбогдох дата мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж урьдчилсан дүгнэлтийг гаргасан. | 2024.06 2024.12 | 70% |
| 2. | Дэд арга хэмжээ 4.1.1 Судалгааны дата мэдээлэл цуглуулах | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 30% | | | |
| 3. | Дэд арга хэмжээ 4.1.2 Судалгааны боловсруулалт хийж дүгнэх | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 70% | | | |
| 4 190 | Арга хэмжээ 4.2. Шаардлагатай харьяа байгууллагуудын бүтэц, дүрмийг шинэчлэх | Батлагдсан тушаалын тоо | 2023 онд яамны харьяа 4 байгууллагын дүрэм, бүтцийн тушаал шинэчлэн батлагдсан. | 2 | - Эрүүл мэндийн сайдын 2024.06.07-ны өдрийн А/ 274 тушаалаар “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дүрэм батлах тухай” тушаал батлагдсан.<br>- УГТЭ-ийн дүрэм, ХСҮТ-ийн дүрэм, бүтэц батлах тухай тушаалын төсөлд 6 | 2024.01.01. 2024.06.01 | 60% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын санааг тусган боловсруулсан. | | |
| **Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 5.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 80-90% | Эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт төлөвлөсөн ажлуудын хүрээнд 80-100% биелэлттэй байна.<br>Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн үүрэг, даалгаврын хүрээнд нэмэлт 2 ажлын төлөвлөгөө хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Процессийн дахин инженерчлэлийн ажлын хэсэгт ажиллах<br>- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллах) | 2024.01.12<br>2024.06.08 | 100% |
| 2. | Арга хэмжээ 5.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд | Хүлээн авч цаг хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | | Хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар:<br>- нийт ирсэн албан бичиг-106 | 2024.01.01<br>2024.12.04 | 100% |

18

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | ХАСХОМ-ын баталгаажилт | | ХАСХОМ-ын баталгаажилт | - өргөдөл, санал, хүсэлт 5-ыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн.<br>- 21 албан бичиг боловсруулж холбогдох газар, иргэнд хүргүүлсэн.<br><br>ХОМ-ийг хугацаанд нь тайлагнаж ЭБАТ-аар баталгаажуулсан. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн үүрэг даалгавар: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт Процессийн дахин инженерчлэлийн ажлын хэсэгт ажиллах | Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ боловсруулах | - | Процессийн дахин инженерчлэл боловсруулах нөхцөл байдлын дүн шинжилгээ хийсэн байх | “Процессийн дахин инженерчлэлийн талаар авах арга хэмжээний тухай “ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажилд яамны ажлын хэсэгт ажилласан.<br>Эрүүл мэндийн салбар дахь процессын дахин инженерчлэлийн судалгаа хийхийн зэрэгцээ бизнес процессын дахин инженерчлэл, процесс зураглал, төслийн удирдлага, манлайлал, багийн ажиллагаа, харилцааны удирдлага, | 2024.03.18<br>2024.04.23 | 100% |

191

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | судалгааны арга зүй зэрэг сэдвүүдээр 7 удаагийн сургалтад хамрагдсан.<br>Төслийн багаас гаргасан “Процессийн дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийх ажлын удирдамж”-ийн дагуу эрүүл мэндийн салбарын нөхцөл байдлын шинжилгээг хийн яамны 70 албан хаагчтай чиг үүргийн шинжилгээний ярилцлага, яамнаас гадагшаа чиглэсэн 22 үйл ажиллагаанд процессийн судалгаа хийн зургийг зурж, 3 удаа 34 оролцогчтойгоор фокус бүлгийн ярилцлага зохион байгуулсан. Хариуцан хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын төслийн багт тайлагнаж урьдчилсан дүнг хэлэлцүүлж ЗГХЭГ-ын даргаас ТАЛАРХАЛ авсан. | | |
| 2. | Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн үүрэг даалгавар:<br>Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах | Ахмад настны тухай хуулийн төсөлд санал боловсруулж тусгах | - | Хуулийн төсөлд санал өгсөн байх | - Ахмад настны тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд яамны холбогдох газруудтай хамтран санал боловсруулж Хууль зүй, Дотоод хэргийн сайдад 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1а/1678 албан бичгээр хүргүүлсэн.<br>- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар | 2024.04.30<br>2024.06.01 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах УИХ-ын НББХ-ны дэд ажлын хэсэгт ажиллаж тус хууль, дагалдаж гарах 11 хуулийн төслийн боловсруулалтад хамтран ажилласан.<br>- Ажлын хэсгээс хуулийн төслийг УИХ-ын НББХ-ны хурлаар 3 удаа, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 удаа хэлэлцүүлэхэд хамтран ажилласан. Хуулийн төсөл 2024.05.22-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцсийн хэлэлцүүлэг нь хийгдэн 2024.06.05-нд ёсчлон батлагдсан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхлэх хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 2.1.1<br>Албан тушаалын чиг үүрэгт хамаарах асуудлаар судалгааны ажил хийнэ. | Судалгааны ажлыг хэвлэн нийтлүүлсэн байна. | | 1 | Азийн хөгжлийн банкны Бүсийн техник туслалцаа: 9928 төслийн хүрээнд “Идэвхитэй насжилтыг дэмжих төв”-ийн дотоод бүтэц, үйл ажиллагаа ба үйлчилгээний зааврудыг | 2024.06<br>2024.12 | 70% |

192

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамтран боловсруулж хэвлэхэд бэлэн болгосон. | | |
| 2. | Арга хэмжээ 2.1.2<br>Зайлшгүй шаардлагатай ур чадварт мэргэжлийн байгууллагаар дамжуулан эсвэл бие даан суралцсан байна. | Бие даан суралцсан байна. | - | 1 | - Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Процессийн дахин инженерчлэл"-ийн ажлын хэсэгт ажиллан VISIO программыг судлан процессийн зураг зурж, процесс уншиж сурсан.<br>- Ажлын байрны чиг үүрэгт дүн шинжилгээ хийх RACI матрицийн аргыг бие даан судалсан.<br>- Удирдлагын академийн "Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" багц цагийн сургалтад хамрагдаж "Үнэмлэх" авсан. | 2024.01<br>2024.06 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Шинжээч — С.Жаргалсайхан / ................... / — 2024.12.04

*(Албан тушаал)* — *(Нэр, гарын үсэг)* — *(Огноо)*

193